

МОНГОЛ УЛСЫН ХАРЪЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬ, БНХАУ- ЫН ХАРЪЯАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Н.Сувд-Эрдэнэ*

Иргэний харьяаллын асуудал нь дэлхий ертөнц улс гүрэнд хуваагдах үед аяндаа бий болж, улмаар олон улсын харилцааны тодорхой салбаруудад илрэлээ олсон. Олон улсын эрх зүйн гол гол баримт бичигт зааснаар, аль нэг улстай эрх зүйн тогтвортой холбоо бүхий хувь хүнийг тухайн улсын иргэн буюу харьяат гэдэг.¹ Энэхүү тогтвортой холбоо нь тухайн иргэн, түүнийг харьяалах улсын төр хоёрын харилцан эдлэх эрх, гүйцэтгэх үүргээр тодорхойлогдох бөгөөд эдгээр эрх, үүргийн цогц нь иргэний улс, төр эрх зүйн статусыг бүрдүүлдэг байна.

Үүгээрээ аль нэг улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс ялгагдана. Тогтвортой гэдэг нь тухайн нэг улсын иргэн эх орондоо байгаа эсэхээс үл шалтгаалан уг холбоо хадгалагдан үйлчилж буйг хэлж байгаа юм. Тухайлбал, манай Харьяатын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4-т: “Монгол Улсын харьяат хаана оршин сууж байгаагаас үл хамааран төрийн ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулна” гэж зааж өгсөн.

Хувь хүн, төр хоёрын эрх зүйн шүтэлцээг харьяалал гэж хэлэхийг дээр дурдсан. Өөрөөр хэлбэл, иргэний харьяалал нь хувь хүн, олон улсын эрх зүйн хоорондын гол холбоос мөн юм. Иймээс иргэний харьяаллын асуудал нь аль ч улсын хувьд чухал бөгөөд эмзэг асуудал байдаг.

Иргэний харьяаллын асуудлыг тухайн улсын үндэсний хууль тогтоомжоор зохицуулдаг² учраас иргэний болон бусад хууль тогтоомжийн заалттай зөрчилдөх явдал байнга гардаг. Үүнийг арилгах зорилгоор улс орнууд хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулж түүнд зааснаар энэхүү асуудлаа зохицуулна. Иргэний харьяаллын салбар дахь эрх зүйн харилцаанд олонхи тохиолдолд гадаадын иргэд болон тухайн улсын хилийн чанадад байгаа иргэд оролцдог тул иргэний харьяалал нь зохицуулах аргаараа олон улсын хувийн эрх зүйтэй ихээхэн холбоотой.

Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай 1966 оны Олон улсын Пактын 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: “Эх орондоо эргэж ирэх хэний ч эрхийг дур мэдэн хасч үл болно” гэснийг үндэслэн өөрийн иргэнийг харьяалах улс нь заавал хүлээж авах үүрэгтэй.

* БНХАУ-ын Өвөрмонголын их сургуулийн докторант

1. Мөн тэнд, 84-р тал

2. Ж.Амарсанаа “Хүний эрх”, УБ., 2000, 83-Р тал

Олон улсын эрх зүйд иргэний харьяалалтай болох арга замын талаар тодорхой заагаагүй ч 1948 оны “Хүний эрхийн түгээмэл Тунхаглал” (15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)-д «Хүн бүр харьяалалтай байх эрхтэй»-г, мөн “Хүүхэд бүр харьяалалтай байх эрхтэй”-г “Хүүхдийн эрхийн тухай” 1959 оны Тунхаглалын 3 дахь зарчим³, 1966 оны Иргэний ба Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт⁴ тус тус зааж өгсөн байна.

Иргэний харьяалалтай болох, харьяаллаа алдахтай холбогдсон асуудал нь улс орны тусгаар тогтнолтой шууд холбоотойн хувьд тухайн улсын үзэмжээр зохицуулагдаж байдаг хүний эрхийн чухал асуудлын нэг юм.⁵ Иргэний харьяалалтай болох, харьяаллаа алдахтай холбоотой хэм хэмжээг улс бүр өөрөө тогтоож, хууль тогтоомждоо тусгаж байдаг. Иргэн болох асуудлыг үндэсний хууль тогтоомжоор шийдвэрлэх хэдий ч энэ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд харшлахгүй байх ёстой. Тухайлбал, үндэсний хууль тогтоомж нь тухайн хүсэлт гаргагчийг арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй байвал зохино. Гагцхүү сайн дурын үндсэнд тулгуурладаг зарчимтай.

“Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй. Аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй”⁶ гэж заасан байдаг. Тэгвэл БНХАУ-ын Харьяаны тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Гадаад улсад нутаглан сууж байгаа Дундад улсын ард иргэн сайн дураараа гадаадын улсын харьяанд орсон буюу гадаадын улсын харьяатай болсон байвал Дундад улсын харьяагаа аяндаа алдсанд тооцогдоно. Мөн хуулийн 12 дугаар зүйлд “Төрийн ажилтан ба одоогийн цэргийн албаны хүн Дундад улсын улсын харьяанаас гарч болохгүй” гэж заасан байдаг нь дээрхтэй илт зөрчилдөж байна гэж үзэж болох талтай.

Монгол Улсын Харьяатын тухай хуулийн 3-р зүйлийн 5.д Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно, БНХАУ-ын иргэний харьяаны тухай хуулийн 2-р зүйлд Бүгд Найрамдах Дундад Ард Улс бол олон үндэстэнтэй нэгдсэн улс мөн. Эл үндэстний хүн бүхэн Дундад улсын харьяатай байна “ гэж тус тус заасан байдаг.

Хувь хүн нэгэн зэрэг нэгээс илүү улсын иргэний харьяалалтай байхыг хоёрдмол болон давхар харьяалал гэнэ.⁷ Энэ нь холбогдох баримт бичгээр нотлогдсон байна.

Гэтэл манай хоёр улсын хуулинд аль алинд нь, тодруулбал, Монгол

3. “Современное международное право” Сборник документов. М., 1964, с.265-268

4. “ Международное право в документах”, М., 1982, с.318-335

5. Б.Чимэд “Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал-1” УБ., 2002, 88-96-р тал

6. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1946 оны 12 дугаар сарын 10-нд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 15 дугаар зүйлийн 1-2-т.

7. О.Пунцагдаш. Иргэний харьяалал, УБ., 2002, 14-р тал

улсын Харьяатын тухай хууль⁸-ийн хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх тухай 4 дүгээр зүйлийн заалт, Хятад улсын Харьяаны тухай хууль⁹-ийн гуравдугаар зүйлд Бүгд Найрамдах Дундад Ард улс нь Дундад улсын ард иргэнийг хоёр улсын харьяатай байхыг зөвшөөрөхгүй байх тухай 3 дугаар зүйлийн заалтууд нь дээрхи олон улсын хууль тогтоомжтой зөрчилдөж байна. Энд хууль зүйн үүднээс агуулгыг нь авч үзвэл харьяатаас хөөж хасаагүй, гэхдээ хуулийн дагуу харьяатаас гаргасан гэх боловч тухайн хувь хүн дээр эцсийн бодит үр дүн нь ялгаагүй юм. Угтаа бол тус тусын улсын харьяалалгүй болно гэсэн үг. Жишээлэхэд Солонгосын хуулиар “Солонгосын иргэнтэй гэрлээд 2 жилийн дараа БНСУ-ын иргэн болох боломжийг амьдралын шаардлагын дагуу ихэнх нь эдэлдэг байна. Ингэхдээ тэд тус тусын улсын харьяатаас гарахыг үнэхээр хүсдэггүй, давхар харьяалалтай байхыг эрмэлздэг байхад Монгол, Хятад хоёр улсын харьяатын тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс тэдгээр гадны иргэнтэй гэрлэсэн иргэдээ тус тусын харьяатаас “албадан” гаргаж байна.

Иргэддээ ийнхүү хатуу хандаж, уугуул иргэдээсээ сайн дураараа татгалзаад байх нь зөв зүйтэй шийдэл мөн эсэх, арай уян хатан эрх зүйн зохицуулалт хийх боломжийг эрэлхийлэх хэрэгтэй юү гэдгийг судлах бодит шаардлага байна. Энэ тохиолдолд төрөлх улсын харьяатаас гарах хүсэлтэй байгаа эсэхийг наад зах нь тогтоож тодруулж байгаад /автоматаар биш/ харьяатаас гаргаж байх тухай нэмэлт, өөрчлөлтийг тус тусын Харьяатын тухай хуульд оруулж болмоор байгаа юм.

Харин угаасаа харийн хүнийг Монгол Улс, Дундад улсын харьяат болгохдоо цаад гадаад улсын харьяатаас гарсан байх шаардлагыг тавих нь хоёрдмол харьяаллыг зөвшөөрөхгүй байх зарчимд нийцэх юм.

Хоёрдмол харьяалал ба бипатрид нь төрөл бүрийн учир шалтгааны улмаас дэлхийн улс гүрнүүдэд хүмүүс нэгэн зэрэг хоёр буюу түүнээс дээш харьяалалтай эсвэл харьяалалгүй болдог тохиолдол цөөнгүй гардаг. Энэ байдал гол төлөв улс орнуудын хууль тогтоомжийн зөрүүгээс үүсдэг байна.

Түүнчлэн нутаг дэвсгэрийн өөрчлөлт, хүн амын цагаачлал, харьяат болох, иргэний харьяаллаа алдах журмын талаархи улс гүрнүүдийн хууль тогтоомжийн зөрүүтэй байдал нь хоёрдмол харьяалал үүсэх гол шалтгаан болдог байна. Ийнхүү нэгэн зэрэг гадаад улсын харьяат байхыг зөвшөөрдөггүй боловч амьдрал дээр давхар харьяалалтай иргэн бий болж тоо нь нэмэгдсээр байгаа. Тухайлбал:

- Хоёр улсын харьяат гэр бүлийн гадаадад төрсөн хүүхэд, гадаадын иргэнтэй гэр бүл болсон иргэний гадаадад төрүүлсэн хүүхэд;
- Түүнчлэн зохих журмын дагуу гадаадын иргэнд үрчлүүлсэн тус

8. <http://www.legalinfo.mn/>

9. <http://www.goy.cn/>, 全国人大法规库。

улсын харьяат хүүхэд дээрх хуульд зааснаар зөвхөн тус улсын харьяат байх боловч тухайн гадаад улс нь үндэснийхээ хуулийн дагуу дээр дурьдсан хүүхдүүдэд өөрийн улсын иргэний харьяаллыг олгосноор;

- Зарим улсад хоёрдмол харьяаллыг хуулиараа хориглодоггүй буюу өөрийн улсын харьяаллаас татгалзахыг шаардахгүйгээр тухайн улсын иргэнтэй гэр бүл болж тодорхой хугацаанд амьдарсан тохиолдолд өөрийн иргэншлийг олгосноор тус тус давхар харьяалалтай болсоор байна.

Тиймээс Монгол улс, БНХАУ-ын иргэд тус тусын улсын харьяатаас гарахгүйгээр, хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг гадаад улсын харьяат болсноос хоёрдмол буюу давхар харьяалалтай болж байна. Энэ тохиолдолд өөрийн улсын харьяатаас гарсан байхыг цаад улс нь шаардахгүй тул эдгээр иргэд тус тусын улсын харьяатын байгууллагад хандах шаардлага гардаггүй байна. Учир нь тэдгээр иргэний харьяаллын асуудлаар ямар нэг бэрхшээл байдаггүй. Ийм байдлаар хоёрдмол харьяалалтай болсон хүний тоог тогтоох боломжгүй.

Судалгаанаас үзэхэд 1980-2006 онд Монгол Улсын харьяатаас гарсан нийт 410 хүний 63.1 хувийг 2000-2006 онд гарсан хүмүүс эзэлж байна¹⁰.

Тэгвэл БНХАУ-ын иргэдийн хувьд Дундадын харьяанаас гарах хэд хэдэн шалтгаан байдаг байна. Үүнд:

- Дундад улсын иргэд гадаадын аль нэг улсын харьяат болсноор бусад өөр улсад зорчих, шилжин суурьших, аялаж жуулчлахад хялбар болдог байна. Өөрөөр хэлбэл гадаадад зорчих, шилжин суурьших зэрэгт визийн асуудал хэт чанга биш байдаг.

- Нэгэнт гадаадын аль нэг улсад зорчиж, улмаар олон жил тухайн улсад шилжин суурьшиж, ажиллаж амьдарсан хүмүүс улсдаа буцаж ирж ажил хөдөлмөр эрхлэх боломж бага. Тиймээс ихэвчлэн шилжин суурьшсан тухайн гадаад улсын хууль журмын дагуу оршин сууж, тодорхой нөхцөл шалгуурыг давж, тухайн улсын харьяанд ордог байна.

- Гадаад улсын нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж өндөр учраас Дундадын иргэд гадаадын харьяаг сонгодог байна¹¹. Ийнхүү гадаадын харьяатыг авахдаа мөн адил давхар харьяалалыг үүсгэж байгаа нь ажиглагдаж байна.

Ийнхүү гадаадад амьдрахаар сэтгэл шулуудсан уугуул иргэд эцэг, эх, элгэн садан гээд нэгэн насны туршид зүрх сэтгэлээс үл тасрах нандин бүхнээ хуулийн хүчээр дурсамж болгон эх орондоо орхидог байна. Одооны хүчин төгөлдөр хуулийн зохицуулалт нь уугуул иргэдэд хувь хүнийх нь хувьд зарим хүндрэл учруулж байна. Учир нь удаан хугацаагаар амьдарч тухайн улсын иргэний харьяаллыг авах шалгуурыг ханган иргэний

10. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын мэдээнээс иш татав.

11. <http://www.baidu.com.cn/> 搜狐社会论坛

харьяаллыг авах тохиолдолд тус хоёр улсын хуулиар хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй тул харьяатаас гарах шаардлагатай болдог. Энэ нь тус тусын улсын эрдэм боловсролтой хийгээд зарим ажил төрөлд дадсан иргэдээ гадаад улсад алдахад хүргэдэг байна.

Тиймээс энэ асуудлаарх хууль тогтоомжоо Монгол улс, БНХАУ аль аль нь эргэн харах шаарлагатай гэж үзэж байна. Монгол Улс, БНХАУ хоёр нь дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн болохын хувьд бусад улсын жишгийг харгалзан үзэж, хууль зөрчигдөх явдлыг таслан зогсоох үүднээс хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх шаардлага байгааг товч авч үзлээ. Тэгвэл Монгол, Хятад Улсын харьяатаас гарч буй иргэдийн талаар судалж, дүгнэлт хийхийг хичээе.

Дээр дурдсан гурван тохиолдолд тус хоёр улсын харьяат хүүхэд гадаад улсын иргэний харьяаллыг авсан ч гэсэн тус тусын улсын харьяат хэвээр үлдэх, хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг гадаад улсын харьяат болсон иргэд иргэнийхээ харьяаллыг хадгалж үлдэхээр буюу өөрөөр хэлбэл, хязгаарлагдмал хүрээнд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөхөөр хуулийн зохицуулалт хийх нь аль ч улсын хувьд зүйтэй гэж үзэж байна.

Тиймээс Монгол Улсын Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1дэх хэсгийн Монгол Улсын иргэн нэгэн зэрэг өөр улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй тухай, БНХАУ-ын харьяаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн БНДАУ-Дундад улсын ард иргэний хоёр улсын харьяатай байхыг зөвшөөрөхгүй тухай заалтуудыг тус тусын хуулиндаа Монгол болон Дундад Улсын иргэн энэ хуульд зааснаас бусад тохиолдолд нэгэн зэрэг өөр улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй байхаар өөрчлөн найруулах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

Миний үзэж байгаагаар хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд бий болгох санал дэвшүүлж, зарим бэрхшээлийг хуулийн хүрээнд уялдуулан зохицуулж болно. Зарим тодорхой улс оронтой олон улсын гэрээ байгуулж хоёрдмол харьяаллын асуудлыг жич тохирох хууль эрх зүйн арга замыг сонгож тодорхой бодлогын хүрээнд хэрэгжүүлж болох билээ. Гэхдээ бидний талаас бодлогын хувьд сонирхсон гадаадын улс орон нь хоёрдмол харьяаллыг харилцан зөвшөөрсөн гэрээ байгуулах гэсэн манай саналд нааштай хандах эсэх нь бас тодорхойгүй зүйл юм. Иймд ямар ч байсан дотоодын хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг түлхүү хэрэгжүүлэх нь бодлогын хувьд зүйтэй юм.

Ийнхүү хоёрдмол харьяалалыг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрсөнөөр:

Нэгдүгээрт: Монгол Улс, БНХАУ-ын харьяат эцэг, эхчүүд гадаадад төрсөн хүүхдээ өөрийн улсын дипломат төлөөлөгчийн газарт бүртгүүлж төрсний гэрчилгээ аваагүй, тухайн гадаад улс нь уг хүүхдэд

иргэнийхээ харьяаллыг олгон паспортоо өгсөнөөс тэд эх орондоо эргэж ирэхдээ өөрийн улсын виз авч ,эмэг эх,өвөг эцэг, төрөл садангийнхаа асрамжинд байхдаа гадаадын иргэний журмаар зөвшөөрөл авдаг байсан нь үгүй болж иргэдэд чирэгдэл багасна.

Хоёрдугаарт: Гадаадын иргэнд үрчлүүлсэн хүүхэд маань гадаад улсын иргэний харьяалалыг авлаа ч гэсэн тэднийг 16 нас хүртэл нь хяналт тавих боломж илүү баталгаажна.

Гуравдугаарт: Тус улсын хувьд боловсрол, мэргэжилтэй өөрийн иргэдийг гадаадад алдах явдал багасна. Дашрамд дурдахад гадаадад буй өөрийн иргэдэд түшиглэн хөгжлөө урагшуулах бодлого баримтлан амжилт олж буй орнууд бий бөгөөд ОХУ, БНУУ зэрэг урьд нь хоёрдмол харьяаллыг зөвшөөрдөггүй байсан улс гадаад улсын иргэний харьяалал авсан өөрийн иргэдийн давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхөөр хуулиндаа өөрчлөлт оруулсан байна.

Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх болсон дэлхийн улсуудын түүхэн, газар зүйн болон хүн ам зүй, хуулиа батлах болсон нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзвэл:

Социалист систем задарч дэлхийн улс төрийн газрын зурагт өөрчлөлт орж түүнтэй холбоотойгоор хоёрдмол харьяаллыг тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрэх болсон байна. Эдгээр улсууд нь социалист системийн үед хүн амын механик шилжилт хөдөлгөөн ихтэй байснаас тухайн улсын голлох үндэстнүүд бусад тусгаар тогтносон улсуудад олноор суурьшин үлдсэнээс хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрсэн. Жишээ дурьдахад ОХУ-ын нийт 150 сая орчим хүн амд 45 сая орчим Украин үндэстэн байхад, Украин улсын нийт 55 орчим сая хүн амын 22 хувийг оросууд эзэлдэг байна.

Колончлолын эрин үе дууссаны үр дагавартай холбоотойгоор зарим улсууд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх болсон. Тухайлбал, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс урьд нь колончилж байсан хамтын нөхөрлөлийн 36 оронд буй иргэдээ тэдний иргэн болгон алдахгүйн тулд давхар харьяалалыг хүлээн зөвшөөрөх болсон байна. Жишээ дурьдахад Английн колони байсан ӨАБНУ-д 5 сая гаруй ангилчууд амьдардаг байна. Зарим тивд тусгаар улсуудын холбоо бий болсонтой холбоотойгоор хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх болсон. Тухайлбал, Европын холбоонд нэгдээд байгаа нийт 25 гишүүн орны иргэдийн хоёрдмол харьяаллыг харилцан зөвшөөрөх болсон байна.

Дээрх асуудалтай уялдан дүгнэж үзэхэд: **нэгдүгээрт:** хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг улсуудын ихэнхи нь өөр улсад оршин суугаа иргэдээ алдахгүй байх зорилгоор, нөгөө талаар тэдгээр иргэдээ эх орондоо шилжүүлэн суурьшуулах хүндрэлтэй нөхцөл байдал зэргээс

шалтгаалан хоёрдмол харьяаллыг зөвшөөрдөг болох, *хоёрдугаарт*: Ийнхүү зөвшөөрөхдөө нөгөө улсынхаа иргэдийн энэхүү эрхийг харилцан хүлээн зөвшөөрдөг болох нь тус тус харагдаж байна.

Өнөө үед иргэдийн гадаадад зорчих, шилжих хөдөлгөөн чөлөөтэй сайн дураар явагдах болсон. Үүний үр дүнд иргэд гадаадын иргэнтэй гэр бүл болох, гадаад оронд хүүхдээ төрүүлэх, гадаад орны хуулийн болон бусад тодорхой болзол шалгуурыг хангасны үндсэн дээр гадаад улсын харьяаллыг авах үзэгдэл гарах болж иргэний хоёрдмол харьяалалтай болгох асуудал амьдралаас урган гарч байна.

Аливаа улс гүрэн нь иргэний харьяаллын асуудлаа ямар нэгэн этгээдээс хараат бус бие даан үндэснийхээ хууль тогтоомжоор нарийн чанд зохицуулдаг хэдий ч энэ нь дэлхий дахинд, бус нутгийн улс төр, нийгмийн байдал, хувьсал өөрчлөлт, хөгжил дэвшлийг даган уян хатан байх шаардлага гардаг байна.

Сүүлийн жилүүдэд даяаршилын үйл явц идэвхжин зарим томоохон улс гүрэн хоёрдмол харьяаллыг зөвшөөрөх хандлага бий болж хоёрдмол харьяалалтай иргэд олноор бий болж цаашид тоо нь өсөх төлөвтэй байгааг харгалзан:

- хууль зөрчигдөх явдлыг үгүй болгох;
- хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх, ашиг сонирхолыг хамгаалах, түүнд нийцүүлэх, хяналтыг сайжруулах;
- иргэдэд учирч буй чирэгдлийг багасгах үүднээс хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд бий болгох арга замыг эрэлхийлж тодорхой хүрээнд судлах хэрэгтэй болж байна. Ийнхүү бодит байдлаа харгалзан хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн нэг тал барьсан хуулиа эргэн харж уг асуудлыг бодлого болгон боловсруулах талаар хэлэлцэх тэр цагт энэхүү ажилд гарсан санал, дүгнэлт уг асуудлын шийдвэрлэх арга замын нэг хувилбар болох талтай.

Түүнчлэн тус хоёр улсын харьяат болохоор хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн боловсролыг харгалзсан шалгуур тогтоох хэрэгтэй. Учир нь боловсрол мэргэжил өндөртэй хүн амтай байх нь улсын үзэмж цаашилбал хөгжил дэвшлийн түлхүүр болдог.

Ашигласан эх сурвалж:

Монгол хэлээр:

1. Ж.Амарсанаа “Хүний эрх”, УБ., 2000 он
2. О.Пунцагдаш. Иргэний харьяалал, УБ., 2002 , 14-р тал
3. Б.Чимэд “Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал-1” УБ ., 2002 он

Орос хэлээр:

1. Современное международное право. Сборник документов. Москва, 1964
2. Международное право В документах, Москва, 1982

Эрх зүйн акт:

1. БНМАУ-ын Харьяатын тухай хууль. 1987 он.
2. БНКАЗУлсын “Харьяаллын тухай хууль”, 1991он.
3. БНХАУ-ын “Иргэний харьяаны тухай хууль” 1980 он.
4. Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт.1966 он.
5. Иргэний харьяаллын тухай Европын конвенци, 1997 он.
6. Монгол Улсын Харьяатын тухай хууль, 1995 он.
7. ОХУ-ын “Иргэний харьяаллын тухай хууль” 1991 он.
8. Харьяалалгүй хүмүүсийг цөөлөх тухай конвенци.
9. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1946 он.
10. Хүүхдийн эрхийн тухай Тунхаглал, 1959 он.
11. Хоёрдмол харьяаллыг арилгах тухай конвенци, 1975 он.
/Монгол-ОХУ/
12. ИБУИНВУ-ын “Иргэний харьяаллын тухай хууль”, 1991 он

Цахим эх сурвалж:

1. <http://www.legalinfo.mn/>
2. <http://www.gov.cn/>, 全国人大法规库。
3. <http://www.baidu.com.cn/> 搜狐社会论坛
4. www.tsahimurtuu.mn